"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд А.Амарын гудамж 15 хаягт байрлах Бэст вестерн премьер туушин зочид буудлын Соёмбо танхимд (танхимаар болон зайнаас) 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт 73.10 хувийн ирцтэйгээр эхлэв.

Хурлын дарга: Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг

Хурлын тооллогын комисс:

Дарга: "Инвескор капитал ҮЦК" ХХК-ийн дотоод хяналтын мэргэжилтэн Ж.Азбаяр

Гишүүд: "Инвескор капитал ҮЦК" ХХК-ийн брокер Т.Солонго

"Инвескор капитал ҮЦК" ХХК-ийн хөрөнгө оруулалтын шинжээч Б.Ундрал

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах;
3. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах;
4. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох;
5. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, батлах;
6. "Монголын хөрөнгиин бирж" ХК-иин Хяналтын зөвлөлиин ажиллах журмын төсөлтэй танилцах;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, шийдвэрлэх.

СОНССОН нь:

Тооллогын комиссын дарга Ж.Азбаяр: "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд 256,173,639 ширхэг хувьцаа эзэмшдэг 104

хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 350,463,539 энгийн хувьцааны 73.10 хувь болж байх тул хурлын ирцийг баталгаажуулан хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлж, Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 73.10 хувийн эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож буйг мэдэгдэв.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Хурлыг нээж үг хэлэв. Ээлжит хурлын дэгийг танилцуулж, хурлын дэгтэй холбоотойгоор саналтай хувьцаа эзэмшигч байгаагүй буюу хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид дэмжсэн тул дэгийг баталсныг мэдэгдэв.

Тооллогын комиссын гишүүн Т.Солонго: Хурлаар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгөв.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Энэ удаагийн хурлын онцлог бол Хөрөнгийн бирж анх удаа олон нийтэд нээлттэй болж, IPO амжилттай хийсэн, нээлттэй хувьцаат компани болсны дараах анхны хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Иймээс Хувьцаа эзэмшигчид Та бүхэндээ Хөрөнгийн биржийн талаар товч танилцуулгыг хүргэнэ. Танилцуулгыг Гүйцэтгэх захирал Х.Алтай хийнэ.

Гүйцэтгэх захирал Х.Алтай: Монголын хөрөнгийн биржийн талаар товч танилцуулгыг хийв.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Танилцуулга хийсэн Алтай захиралд баярлалаа. Ингээд хөтөлбөрийнхөө дагуу эхний хэлэлцэх асуудал руугаа оръё. “Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах” асуудал байгаа, танилцуулгыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Тулга хийнэ.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагаа, 2023 оны эхний 4 сарын баидлаарх үил ажиллагааны талаар танилцуулав.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Танилцуулга хийсэн Тулга даргад баярлалаа. Танилцуулгатай холбогдолтой асуулт, хариулт хурлын дэгийн дагуу явагдана. Хэдэн зүйлийг Та бүхэнд анхааруулж хэлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой асуулт асуух ба асуулт асуух хугацаа 1 минут байна. Та бүхний асуултад хариулахаар Монголын хөрөнгийн биржийн удирдлагууд бүрэн бүрэлдэхүүнээрээ, мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд энэ зааланд сууж

байгаа. Хурлын тэмдэглэл хийгдэх учир асуулт асууж буй Хувьцаа эзэмшигч Та овог, нэрээ хэлээрэй. Эхлээд заалнаас асуулт аваад, дараа нь цахимаар асуултаа аваад явъя.

Асуулт, хариулт, санал: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуугаагүй болно.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Заалнаас болон цахимаар асуулт байхгүй байна. Маш ойлгомжтой тайлан, мэдээллийг Тулга дарга өгсөн байна гэж харж байна. Ингээд дараагийн асуудал руугаа оръё. Хоёр дахь асуудал, ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн үндэслэлтэй танилцана. Тулга дарга танилцуулга хийнэ үү.

2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: Өнгөрсөн 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын үндэслэлийг тайлагнав.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Ногдол ашигтай холбогдолтой асуулт асуух Хувьцаа эзэмшигч байгаа эсэхийг тодруулж, хурлын тэмдэглэл явагдаж байгаа тул асуулт асуухдаа овог, нэрээ эхэлж хэлэхийг сануулав.

Асуулт, хариулт, санал: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор 1 хувьцаа эзэмшигч асуулт асууж, хариулт авав. Мөн 1 хувьцаа эзэмшигчийн зүгээс санал хэлж, уг саналыг цаашид анхаарч ажиллах нь зүйтэйг Хурлын дарга цохон тэмдэглэв. Түүнчлэн, 2 хувьцаа эзэмшигчийн зүгээс хэлэлцэж буй асуудалтай холбогдолгүй, компанийн үйл ажиллагааны талаар асуулт асуулаа.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Та бүхэн хурлын дэгийн дагуу хэлэлцэж буй асуудалтай холбогдолтой асуулт асууна уу. Хурал маань тусгай дэгээр явна. Таны асуусан асуулт хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй асуулт байна. Гэхдээ Таны асуусан асуултад хурлын дараа эсхүл хурлын завсарлагаагаар мэдээлэл өгөөд явъя. Өөр асуулт байна уу, цахимаар байна уу? /Асуулт байгаагүй болно/ Заалнаас 4 хүн асуулт асуулаа. Нэг хүний асуулт хэлэлцэж буй асуудалтай холбогдолгүй учраас дараа нь ажлын шугамаар холбогдох хариултыг өгөх болно. Хөтөлбөрийн дагуу 3 дахь хэлэлцэх асуудал руугаа оръё. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэнэ. Танилцуулгыг Х.Алтай захирал хийнэ.

3. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах

Гүйцэтгэх захирал Х.Алтай: Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг өнгөрсөн 2022 оны гүйцэтгэлийн хамт танилцуулав.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Танилцуулга хийсэн Алтай захиралд баярлалаа. Энэ оны компанийн зорьж байгаа эдийн засгийн үзүүлэлтүүд, түвшнийг Та бүхэнд танилцууллаа. Танилцуулгатай холбоотой асуултыг заалнаас, бас цахимаар авъя. Энэ жил компанийн үйл ажиллагаа далайцтай өргөжнө, үүнтэй уялдуулаад орлого нэмэгдэнэ, зарлага талдаа ч нэмэгдэх юм байна гэсэн үзүүлэлтүүдийг танилцууллаа. Энэ тал дээр Хувьцаа эзэмшигчдийн зүгээс тодруулах асуултууд байгаа байх аа гэж бодож байна.

Асуулт, хариулт, санал: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор 5 хувьцаа эзэмшигч асуулт асууж, санал хэлэв. Асуултуудад Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга, Гүйцэтгэх захирал Х.Алтай нар хариулт өглөө.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Өөр асуулт асуух Хувьцаа эзэмшигч байн уу? Цахимаар асуулт байна уу? /Асуулт байгаагүй болно/ Гурав дахь хэлэлцэх асуудлаар 5 хувьцаа эзэмшигч тодруулж, асуулаа. Олон нийтэд нээлттэй компани болсны үр дүн нь Та бүхний асууж тодруулж байгаа компанийн үйл ажиллагааг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулах зэрэг олон асуудлыг хөндөж ярьж байгаагаар түрүүчээсээ гарч байна гэж харж байна. Одоо 4 дэх асуудал буюу "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох асуудал руугаа оръё. Танилцуулгыг Алтай захирал хийнэ.

4. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох

Гүйцэтгэх захирал Х.Алтай: "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох талаар танилцуулав.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Танилцуулгатай холбоотой асуулт заалнаас болон цахимаар авъя.

Асуулт, хариулт, санал: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуугаагүй болно.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Асуулт байхгүй байна. Компанийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр нэмэгдүүлдэг. Үүнийгээ компанийн дүрэмд тусгах шаардлагатай байдаг. Энэ хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай асуудал нь өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлын нэг болж байгаа юм. Энэ асуудалтай холбогдолтой асуулт байхгүй учраас энэ асуудлаа хаагаад, дараагийн асуудал руугаа оръё. Хөтөлбөрийн дагуу бидэнд завсарлага гэзд 30 минут байна. Хуралд оролцож байгаа Та бүхнээс завсарлагагүйгээр шууд

үргэлжлүүлэх эсхүл завсарлага авах талаар санал асууя. /Танхимаар оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн олонх завсарлагагүй үргэлжлүүлэх саналтай байв/ Нийт оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийнхээ саналаар, завсарлагагүйгээр 30 минутаа хэмнээд, шууд үргэлжлүүлье. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэнэ. Танилцуулгыг Алтай захирал хийнэ.

5. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, батлах

Гүйцэтгэх захирал Х.Алтай: "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: Компанийн шинэчилсэн дүрэмтэй холбогдуулаад асуулт байна уу?

Асуулт, хариулт, санал: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор 2 хувьцаа эзэмшигч зарчмын санал хэлэв.

Хувьцаа эзэмшигч н.Зоригтбаяр: Дөрөвдүгээр зүйл дээр, Хувьцаа эзэмшигчдийн хурал гэсэн хэсгийн 4.3.2 дээр ийм заалт байна: саналын эрхтэй хувьцааны 10 буюу түүнээс хувийн хувьцаа дангаар эзэмшигч санал, шаардлага гаргасан тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулна" Энийг дангаар биш хамтран хувьцаа эзэмшигчид гэсэн байдлаар өөрчлөх санал байна.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Саяны хувьцаа эзэмшигчийн хэлсэн саналыг дүрмийн төсөл дээрээ санал хураагаад, оруулаад явах нь зүйтэй байх аа. Дангаараа гэхээр жижиг хувьцаа эзэмшигч нар маань хурлыг хуралдуулах эрх нь нээгдэхгүй байна гэж харж байна. Өөр асуулт байна уу? Өнөөдрийн хэлэлцэж буй 7 долоон асуудлаар хурлын төгсгөлд санал хураагаад, тогтоолын төсөл батлаад явна. Нэгдсэн санал хураалт дээр саяны санал дээр тусгайлан санал хураагаад шийдье. Саналын хуудасныхаа хойно саяны асуудлыг бичээд өгөөрэй. Дүрмийн тэдийн тэдэд ийм өөрчлөлт оруулна аа гээд.

Хувьцаа эзэмшигч н.Чинбат: Саналын шинжтэй юм байна. 7 дугаар бүлэгт Хяналтын тогтолцоо гээд Хяналтын зөвлөл байна. 7.5.7-д "гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх" гэсэн байна. Энийг гүйцэтгэх удирдлага дээр байгаатай адил "эдийн засгийн гэмт хэрэг" гэж өөрчлөхгүй бол магадгүй 7 сарын 1 гэдэг ч юм уу, олон нийтийн үймээн самууны үеэр шүүхийн тогтоол гараад торгуулчихсан хүн Хяналтын зөвлөлд орж ажиллах боломжгүй болж байна.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Саналын хуудсан дээрээ мөн бичээд өгөөрэй. Асуулт байхгүй, дүрмийн төсөл дээр засвар оруулах хоёр санал гарлаа. Цахимаар асуулт байгаа юу? /Цахимаар асуулт, санал байгаагүй болно/ За тэгвэл дараагийн асуудал руугаа оръё. Компанийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын

төслийг танилцуулахаар байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Тулга танилцуулна.

6. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөлтэй танилцах

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төслийг танилцуулав.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Хяналтын зөвлөлийн журамтай холбогдолтой асуулт заалнаас болон цахимаар авъя.

Асуулт, хариулт, санал: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор 2 хувьцаа эзэмшигч зарчмын санал хэлэв.

Хувьцаа эзэмшигч н.Нямдорж: Хяналтын зөвлөлийн чиг үүрэг бол жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах юм. Энэ дээр яагаад мэргэжлийн, үнэт цаасны компаниудыг шууд хориглочихож байгаа юм бол оо? Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг мэргэжлийн байгууллагууд, үнэт цаасны компаниудын төлөөлөл хамгаалж, дуу хоолойгоо өргөх ёстой байх. Ер нь бол Төлөөлөн удирдах зөвлөлийг шууд улирааж байна. Энэ нь өөрөө одоо ... Нээлттэй хувьцаат компани болж байгаагийн гол давуу тал нь засаглалаа сайжруулах. Гэтэл Төлөөлөн удирдах зөвлөл нь төрийн өмчит байсан тэр бүрэлдэхүүнээрээ гэдэг нь байж болшгүй асуудал байна. Төлөөлөн удирдах зөвлөлдөө ч тэр, Хяналтын зөвлөлдөө ч тэр мэргэжлийн байгууллагуудыг оруулаач ээ. Энийг бол би төсөл гэж ойлгож байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх байх. Хэлэлцээд мэргэжлийн байгууллагуудыг оруулаад, магадгүй дан мэргэжлийн болгоод, Хяналтын зөвлөлөө ахлуулах байдлаар ажиллуулаасай гэж хүсэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: Үүн дээр мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гэж байгаа. Эрх бүхий албан тушаалтан гэхээр ТУЗ-ийн гишүүн, ерөнхий нягтлан, гүйцэтгэх захирал. Бусад мэргэжлийн байгууллагын төлөөлөл орох асуудал нээлттэй. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах Хяналтын зөвлөлд орчихоод өөрийн компанитай холбоотой шийдвэр дээр тодорхой нөлөө үзүүлэх боломжтой юм байна гэдэг дээр IPO хийж байхдаа хуулийн зөвлөх компанитай ярилцсан. Гэхдээ мэргэжлийн компани гэж хязгаарлаагүй, зөвхөн эрх бүхий албан тушаалтан гэдэг хязгаарлалт байгаа. ТУЗ-ийн гишүүдийг улируулж байгаа асуудлыг дараа танилцуулах учраас Та тэрэн дээр асуултаа асуугаарай.

Хувьцаа эзэмшигч н.Нямдорж: Зах зээл дээр ажиллаж байгаа, мэдлэг ур чадвартай мэргэжилтнүүд өөрөө аяндаа 5-10 жил туршлагатай, эрх бүхий албан тушаалтнууд болчихсон байгаа. Дөнгөж сургууль төгссөн хүүхдүүд, шинэ мэргэжилтнүүд энэ зөвлөлд ороод төдийлөн үр дүн гаргахгүй байх л даа. Тэгэхээр

эрх бүхий албан тушаалтан гэдэг чинь өөрөө мэдлэг, туршлага, чадвартай л хүнийг хэлээд байгаа юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: За ойлголоо. Та саналаа саналын хуудсан дээр бичээд өгөөрэй. Энийг бол хуулийн фирмтэй ярьж байгаад, дараа нь ашиг сонирхлын зөрчил гарах энэ эрсдэлээс хамгаалсан ийм л заалт байгаа юм. Тэр бүгдийг зөвөөр ойлгоорой. Түүнээс бол мэргэжлийн байгууллагыг хязгаарлаад байгаа ямар ч асуудал байхгүй.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Өөр асуулт байна уу? Саяны асуудлыг саналын хуудсан дээрээ тодорхой бичээд өгөөрэй. Цахимаар асуулт байна уу? /Цахимаар асуулт, санал байгаагүй болно/

Хувьцаа эзэмшигч н.Өлзийбаяр: Саяны Нямдоржийн хэлсэн дээр дахиад нэг юм нэмэхэд, саналаа биччихээрэй гэхээр бас өрөөсгөл байхгүй юу. Хяналтын зөвлөлийн журмыг батлах гээд байна шүү дээ, бид нар. Тэгэхээр өөрчлөлт оруулаад батлах уу, үгүй юу гэдгийг ярих ёстой болохоос биш. Та нарын оруулж ирсэн төсөл шиг, эрх бүхий албан тушаалтан оруулахгүй гээд батлах гээд байна уу бид өнөөдөр? Эсвэл журмын төсөлд оруулж байж батлах гээд байна уу?

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Оруулах, үгүйгээ шийдээд. Оруулахаар шийдвэл оруулаад батална. Оруулахгүй бол оруулаагүйгээр батална.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: Хэрвээ Та бүхэн хөтөлбөртэйгөө танилцсан бол санал хураалтыг болохоор санал гаргасан гишүүдийн бичиж өгснөөр саналын товъёогийг дараа нь танилцуулна. Тусгасан, тусгаагүй гэдэг дээр санал хураана.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Санал хураалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулна. Саяны асуудлыг яг томьёоллоор нь санал хураана.

Хувьцаа эзэмшигч н.Нямдорж: Нэг хүн нэг санал гэж явах уу?

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: Эзэмшиж буй хувьцааны тоогоор

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор гарсан санал дээр санал хураагаад шийдээд явна. Хувьцаа эзэмшигчдийн энэ хурлаар Хяналтын зөвлөлийн журамтай болж байна. Энэ журмын дагуу Нэр дэвшүүлэх хороон дээр энэ зөвлөлд орж ажиллах сонирхолтой хүмүүс маань анкет, материалаа өгөөд, сонгон шалгаруулалтаар бүрэлдэхүүн нь шийдэгдэнэ. Ингээд хөтөлбөрийн дагуу сүүлийн асуудал руугаа оръё. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэнэ. Тулга дарга танилцуулгаа хийнэ үү.

7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, шийдвэрлэх

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар танилцуулав.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: За, асуулт авъя.

Асуулт, хариулт, санал: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор 4 хувьцаа эзэмшигч асуулт асууж, хариулт авав.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: ТУЗ-ийн гишүүдийг яагаад 2 сарын хугацаанд улируулан сонгох болсон гэдгийг маш тодорхой Та бүхэндээ тайлбарлаж өглөө. 34 хувийн оролцоог хангах үүднээс ТУЗ-д хоёр гишүүнийг оруулах боломж байна. Энэ нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль эрх зүйн хүрээнд юм. Энэ хүрээнд өнөөдрийн хурлаас гарах тогтоолд тодорхой заалт орно. 10 хоногийн дотор 2 гишүүнийг сонгон шалгаруулж томилох эрхийг өгөх байдлаар зохицуулал. хийгдэнэ. ТУЗ-ийн гишүүдийг одоогийн бүрэлдэхүүнээр сунгаад явах саналыг Сангийн яамнаас гаргасан учир нь одоогийн ТУЗ "эхэлсэн ажлаа дуусгах", 7 дугаар сарын 1 гэхэд шинэ хуулийн хүрээнд ТУЗ нь нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгогдох учир тэр хүртэл хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журмуудыг бүрэн хийж дуусгах, дараагийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулаад өөрсдөө орох нь хаалттай байх гэсэн шалтгаантай. Хөрөнгийн биржийн онцлогоос шалтгаалаад энэ удаа ийм түр, богино хугацааны асуудал гарсан. Түүнээс бусад төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл нь ийм зарчмаар явна гэсэн үг биш гэдгийг тодотгож хэлье. Өөр санал байна уу? Цахимаар санал байна уу? Цахимаар ирсэн 1 асуултад Тулга дарга сая хариулчихаж байгаа юм байна. Хөтөлбөрийн дагуу бид 30 минут завсарлах байгаа, цайны завсарлага. Энэ хооронд өнөөдрийн хурлаар хэлэлцсэн асуудал дээр Та бүхэн санал өгнө. Бичгээр болон цахимаар өгнө. Завсарлаж орж ирсний дараа Тоолллогын комисс дүнг танилцуулаад, хурлын шийдвэр, тогтоол танилцуулагдаад өнөөдрийн хурал дуусах төлөвлөгөөтэй байна. Ингээд 30 минут завсарлая.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга: Хувьцаа эзэмшигчдэдээ хэлэх нэг хүсэлт байна. ТУЗ материал хүлээж авна, ажлын 5 өдрийн дотор. Тэгэхээр хувьцаа эзэмшигчид маань материал ирүүлэхдээ бичиг баримтын иж бүрдлийг хангаад тамга тэмдэг, гарын үсэг, компаниин хуульд заасан шаардлагыг хангаад гүйцэд ирүүлээрэй гэдэг хүсэлт байна. Яагаад гэвэл манай ТУЗ сонгон шалгаруулалт дээр ажиллана. Дараа нь материал дутуу өгчихөөд намайг сонгон шалгаруулсангүй гэдэг асуудал гарах болов уу гэж бодож байна. Тэгэхээр Та бүхэн материалаа гүйцэд бүрдүүлж өгөөрэй, дараа нь хэн хэнийгээ хардаж сэрдэх асуудал гаргахгүйн үүднээс. Хугацаанд нь мөн өгөөрэй.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: За, 30 минутын завсарлага. 13:00 цаг гээд энэ зааландаа цуглая.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Хувьцаа эзэмшигчдээс Дүрмийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын саналыг товъёогийг танилцуулав. Дүрмийн төслийн 4.3.2-т "дангаар эзэмшигч" гэснийг "эзэмшигчид" болгон өөрчлөх санал гаргасан. Уг саналаар өөрчлөх боломжгүй гэж харагдаж байна. Учир нь Компанийн тухай хуулийн 61.1.2-той зөрчилдөх тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал хурааж шийдвэрлэх боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, Компанийн тухай хуулийг зөрчсөн дүрэмтэй болох учраас энэ дээр санал хураахгүй юм байна. Хяналтын зөвлөлтэй холбоотой хоёр санал бол тусгах боломжтой, хууль эрх зүйн хувьд ямар нэгэн зөрчил байхгүй гэдэг үүднээс уг хоёр санал дээр санал хурааж, олонхын саналаар шийдээд явах нь зүйтэй байна. Ингээд Хувьцаа эзэмшигч н.Нямдоржийн гаргасан санал буюу "үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан, эсхүл түүний холбогдох бус этгээд байх" гэдэг заалтыг хасах томьёоллоор санал хураая. Энэ заалтыг хасахыг дэмжиж байна гэдгээрээ гараа өргөөд явъя. Тооллогын комисс хэдэн хүн дэмжиж байна, татгалзаж байна гэдэг тоогоо аваад явах нь зүйтэй. Санал бол хувьцааны тоогоор байна. Дараагийнх мөн Хяналтын зөвлөлтэй холбоотой, Хувьцаа эзэмшигч н.Чинбатын гаргасан санал байна. 7.5.7-д "Гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх" гэснийг "төрийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй" гэж өөрчлөх. Энэ саналыг дэмжиж байна гэдгээр гараа өргөөд шийдээд явъя. Татгалзаж байгаа, түдгэлзэж байгаа Хувьцаа эзэмшигч байхгүй байна. Иймээс санал хурааж, дэмжигдсэн хоёр саналыг Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөлдөө тусгаад явна. За ингээд санал хураалтын дүнг нэгтгэн тогтоолоо танилцуулна уу хэмээн Тооллогын комиссыг урьж байна. Тооллогын комиссоос дүнгээ нэгтгэх 10 минутын завсарлага хүсэж байна. Завсарлагын цаг эхэлж байна.

Тооллогын комиссын гишүүн Б.Ундрал: Санал хураалтын дүн, Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Хурлын дарга С.Мөнгөнчимэг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолуудыг танилцуулж, хаалтын үг хэлснээр хурлыг хаав.

Санал хураалтын дүнгийн тухай

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 95.67% буюу 245,085,628 ширхэг хувьцаатай 51 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
   Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.97% зөвшөөрсөн, 0.02% татгалзсан, 0.01% түдгэлзсэн байна.
   - Зөвшөөрсөн 245,044,149 ширхэг хувьцаа буюу 99.97 хувь,

- Татгалзсан 40,984 ширхэг хувьцаа буюу 0.02 хувь,
- Түдгэлзсэн 495 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь,

2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 95.67% буюу 245,085,628 ширхэг хувьцаатай 51 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
   Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 97.90% зөвшөөрсөн, 2.09% татгалзсан, 0.01% түдгэлзсэн байна.
   - Зөвшөөрсөн 239,952,459 ширхэг хувьцаа буюу 97.90 хувь,
   - Татгалзсан 5,132,619 ширхэг хувьцаа буюу 2.09 хувь,
   - Түдгэлзсэн 550 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь,

3. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт эзэмшигчдийн 95.67% буюу 245,085,628 ширхэг хувьцаатай 51 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
   Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 98.80% зөвшөөрсөн, 0.01% татгалзсан, 1.19 % түдгэлзсэн байна.
   - Зөвшөөрсөн 242,167,472 ширхэг хувьцаа буюу 98.80 хувь,
   - Татгалзсан 625 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь
   - Түдгэлзсэн 2,917,531ширхэг хувьцаа буюу 1.19 хувь,

4. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 95.67% буюу 245,085,628 ширхэг хувьцаатай 51 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
   Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.98% зөвшөөрсөн, 0.01% татгалзсан, 0.01% түдгэлзсэн байна.
   - Зөвшөөрсөн 245,084,508 ширхэг хувьцаа буюу 99.98 хувь,
   - Татгалзсан 625 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь,
   - Түдгэлзсэн 495 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь,

5. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 95.67% буюу 245,085,628 ширхэг хувьцаатай 51 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 98.81% зөвшөөрсөн, 0.41% татгалзсан, 0.78% түдгэлзсэн байна.
   - Зөвшөөрсөн 242,180,195 ширхэг хувьцаа буюу 98.81 хувь,
   - Татгалзсан 1,000,625ширхэг хувьцаа буюу 0.41 хувь,
   - Түдгэлзсэн 1,904,808 ширхэг хувьцаа буюу 0.78 хувь,

6. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг танилцах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 95.67%

буюу 245,085,628 ширхэг хувьцаатай 51 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 96.73% зөвшөөрсөн, 3.26% татгалзсан, 0.01% түдгэлзсэн байна.

- Зөвшөөрсөн 237,088,230 ширхэг хувьцаа буюу 96.73 хувь,
- Татгалзсан 7,996,126 ширхэг хувьцаа буюу 3.26 хувь,
- Түдгэлзсэн 1,272 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь,

7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, шийдвэрлэх тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 95.67% буюу 245,085,628 ширхэг хувьцаатай 51 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 98.35% зөвшөөрсөн, 1.64 % татгалзсан, 0.01% түдгэлзсэн байна.

- Зөвшөөрсөн 241,071,008 ширхэг хувьцаа буюу 98.35 хувь,
- Татгалзсан 4,014,125 ширхэг хувьцаа буюу 1.64 хувь,
- Түдгэлзсэн 495 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь,

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлав;

1.1. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /С.Тулга/-д даалгав.

2. Компанийн 2022 оны цэвэр ашгийн дүнгээс ногдол ашиг хуваарилах нь Компанийн тухай хууль, компанийн ногдол ашгийн бодлогод тусгагдсан ногдол ашиг хуваарилах нөхцөлийг хангахгүй байх тул Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг дэмжив;

2.1. Энэхүү тогтоолыг Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох журмын дагуу хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Мөнхзул/-д даалгав;

2.2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д үүрэг болгов.

3. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг хавсралт ёсоор батлав;

3.1. Батлагдсан зорилтот түвшинд хүрэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д тус тус даалгав.

4. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 350,463,539 /гурван зуун тавин сая дөрвөн

зуун жаран гурван мянга таван зуун гучин ес/ ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 35,046,353,900 /гучин таван тэрбум дөчин зургаан сая гурван зуун тавин гурван мянга есөн зуу/ төгрөгөөр тогтоов.

5. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралт ёсоор батлав;

5.1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгов;

5.2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д даалгав.

6. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төслийг дараагийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр тогтов;

6.1. Хяналтын зөвлөлийн гишүүнийг томилох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороонд үүрэг болгов;

6.2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д үүрэг болгов.

7. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хүртэл хугацаанд улируулан сонгов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

Д.Баянзул
Ч.Дондогмаа
Л.Наранчимэг
М.Санжаадорж
С.Тулга
Д.Энхбаатар

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

А.Анар
А.Батпүрэв
Р.Гандиймаа

7.1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулж, компанийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцүүлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дахин сонгохоор тогтов;

7.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нийцүүлсэн байдлаар компанийн Дүрмийн төсөл боловсруулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгав;

7.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нийцүүлсэн байдлаар компанийн Дүрмийн төсөл боловсруулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгав;

7.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар сонгох Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороонд даалгав;

7.4. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүдийг орлох этгээдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдах хүртэлх хугацаанд дараах шаардлагыг хангасан этгээдээс боловсрол, ажлын туршлага (үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн чиглэлээр) зэргийг харгалзан 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн дотор сонгон шалгаруулж, түр томилохыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгав. Үүнд:

- "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигч байх;
- Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6 дахь хэсэгт заасны дагуу хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх;
- Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт болон холбогдох материалын бүрдлийг хангаж, 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 17:30 цагийн дотор Төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлсэн байх.

7.5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Мөнхзул/-д даалгав.

ХУРЛЫН ДАРГА С.МӨНГӨНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Мөнхзул